

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙГ УРВУУЛАН АШИГЛАХААС СЭРГИЙЛЭХ БОЛОН ДОТООД МЭДЭЭЛЭЛТЭЙ ХОЛБООТОЙ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Санхүүгийн зохицуулах хорооноос /цаашид “Хороо” гэх/ үнэт цаасны зах зээл дэх дотоод мэдээлэлд хамаарах мэдээллийн агуулга, жагсаалт болон дотоод мэдээлэл эзэмшигчийг тодорхойлох, дотоод мэдээлэл эзэмшигчийн үнэт цаасны зах зээлд явуулах үйл ажиллагааг зохицуулах, түүнчлэн үнэт цаасны зах зээлд оролцогчид, тэдгээрийн эрх бүхий албан тушаалтан, холбогдох этгээд үнэт цаасны үнэ ханшийг зохиомлоор тогтоох, зах зээлийг урвуулан ашиглахаас урьдчилан сэргийлэх, зөрчлийг хянан шалгах, таслан зогсоохтой холбогдсон харилцааг энэ журмаар зохицуулна.

1.2. Үнэт цаасны зах зээлийг урвуулан ашиглах гэдэгт “Үнэт цаасны зах зээлд хуурамч арилжаа хийх, үнэт цаасны үнэ ханшийг зохиомлоор тогтоох, үнэт цаасны зах зээлд оролцогч харилцагчийг хууран мэхлэх үйлдэл” гэж томъёолсон Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 80.1-80.4 дэх хэсэгт заасныг ойлгоно.

1.3. “Үнэт цаасны зах зээлд оролцогч, зохицуулалттай этгээд, холбогдох этгээд, дотоод мэдээлэл, дотоод мэдээлэл эзэмшигч” гэснийг Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4.1.16, 4.1.17, 4.1.30, 76.1, 77-д заасныг, “эрх бүхий албан тушаалтан” гэж Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.1-д заасныг буюу үнэт цаас гаргагч болон хөрөнгө оруулагч, тэдгээрийн холбогдох этгээд; зохицуулалттай этгээд, түүний эрх бүхий албан тушаалтан, тэдгээрийн холбогдох этгээд; Хорооны эрх бүхий албан тушаалтан, мэргэжилтэн, ажилтан, тэдгээрийн холбогдох этгээд; үнэт цаасны дотоод мэдээлэл эзэмшигч, тэдгээрийн холбогдох этгээдийг тус тус ойлгоно.

Хоёр. Үнэт цаасны дотоод мэдээлэл

2.1. Дотоод мэдээлэлд дараах мэдээлэл хамаарна: 2.1.1. хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн бүртгэл /Хувьцаа эзэмшигчийн овог, нэр, түүний өмчлөлд буй үнэт цаасны тоо, оршин суугаа хаяг/;

2.1.2. үнэт цаасны клирингийн, төлбөр тооцооны, хадгаламжийн байгууллага, кастодиан банк дахь харилцагчийн үндсэн болон холболтын дансны мэдээлэл;

2.1.3. зохицуулалттай этгээдтэй байгуулсан харилцагчийн гэрээ, үнэт цаас эзэмшигчийн үнэт цаасны зах зээлд ажиллах бодлого, зорилго, үйл ажиллагаатай холбогдсон мэдээ баримт;

2.1.4. үнэт цаасны зах зээлд оролцогчдын үйл ажиллагаанд Хорооноос болон эрх бүхий байгууллагаас хийсэн шалгалтын тайлан, бусад материалд орсон нийтэд тараагдаагүй мэдээ баримт;

2.1.5. үнэт цаасны клирингийн, төлбөр тооцооны, төвлөрсөн хадгаламжийн, кастодианы үйл ажиллагаа явуулахад хэрэглэдэг тооцоолох машины санах байгууламжид агуулж байгаа мэдээ;

2.1.6. үнэт цаасны арилжааны гүйлгээний мэдээ, дансны хуулга, харилцагчдын захиалгын сангийн мэдээлэл;

2.1.7. үнэт цаас гаргагчийн өмчийн үнийн дүнгийн 25 болон түүнээс дээш хувийн өөрчлөлт;

2.1.8. үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа, бизнесийн орчинд гарсан томоохон өөрчлөлтүүд;

- 2.1.9.үнэт цаас гаргагчийн ашиг, алдагдал 25 болон түүнээс дээш хувиар өөрчлөгдөх;
- 2.1.10.үнэт цаас гаргагчийн өөрийн хөрөнгийн 25 хувь болон түүнээс дээш хэмжээтэй тэнцэх хэмжээний өр, зээлийн өөрчлөлт;
- 2.1.11.үнэт цаас гаргагч шинэ төрлийн үйл ажиллагаа эхлэх, үйл ажиллагааг зогсоох, үйл ажиллагаагаа худалдах;
- 2.1.12.үнэт цаас гаргагчийн борлуулалтын орлогын 25-аас дээш хувийг эзлэх үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл түдгэлзэх, хүчингүй болох, эсхүл хуульд заасан тохиолдолд худалдах, бэлэглэх зэрэг аливаа хэлбэрээр бусдад шилжүүлэх;
- 2.1.13.үнэт цаас гаргагчийн хөрөнгө, өр төлбөр, хувьцаа эзэмшигчдийн өмч болон үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд чухал нөлөө үзүүлэх гэрээ боловсруулалтын шатанд болон батлагдсан;
- 2.1.14.санхүүгийн тайлангийн гол үзүүлэлтүүд нь өмнөх жилүүдийн болон ирээдүйд төлөвлөсөн тооцооноос 25 хувиас илүү хэмжээгээр өөрчлөгдөх;
- 2.1.15.үнэт цаас гаргагч нь өөрийн хөрөнгийн 15 хувь болон түүнээс дээш хэмжээний өр төлбөр, нийт хөрөнгийн 2 хувь болон түүнээс дээш хэмжээний хүү, алданги, торгууль төлөх үүрэг үүссэн тохиолдол;
- 2.1.16.хөрөнгө оруулалт, санхүүжилттэй холбоотой чухал шийдвэр гарсан (томоохон хэмжээний хөрөнгө оруулалт хийх, хөрөнгө худалдаж авах, шинэ бүтээгдэхүүн гаргах, шинэ техник, технологийг нэвтрүүлэх);
- 2.1.17.шинэ нээлт хийх, патент авах, ач холбогдол бүхий тусгай зөвшөөрөл эзэмших;
- 2.1.18.үнэт цаас гаргагчийн ирээдүйн үйл ажиллагаанд нөлөөлөх ач холбогдол бүхий арга хэмжээнүүд;
- 2.1.19.үнэт цаас гаргагчийн удирдлагын бүтэц, хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэгч этгээдийн бүтцэд орсон өөрчлөлтүүд;
- 2.1.20.хувьцааны хяналтын багцыг аливаа этгээд дангаараа, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран худалдан авахаар тохиролцоонд хүрсэн, авсан;
- 2.1.21.үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтны өмчлөлд байгаа хувьцааны багцад 5-аас дээш хувиар өөрчлөлт орсон;
- 2.1.22.үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааг нь зогсоохоор нэхэмжлэл гаргасан, түүний эрх бүхий албан тушаалтан, хувьцааны хяналтын багц эзэмшигчдийн үйлдэлтэй холбоотой асуудлаар хууль хяналтын байгууллагад хэрэг үүсгэгдсэн, эсхүл тэдгээр этгээд гэмт хэрэг үйлдсэн нь тогтоогдож, хуулийн дагуу шийтгэгдсэн;
- 2.1.23.үнэт цаас гаргагч нь охин болон хараат компанитай болсон;
- 2.1.24.охин болон хараат компанийн үйл ажиллагаа, хөрөнгө, эзэмшигчдийн өмч, өр, төлбөр, ашигт гарсан томоохон өөрчлөлтүүд;
- 2.1.25.үнэт цаас гаргагч ногдол ашиг хуваарилах шийдвэр болон ногдол ашиг тараахтай холбогдсон бусад мэдээлэл;
- 2.1.26.Хороо, хөрөнгийн бирж, бусад эрх бүхий байгууллагаас бүртгэлтэй үнэт цаасны арилжааг түр зогсоох, бүртгэлээс хасах шийдвэр гарсан;
- 2.1.27.үнэт цаас гаргагч нь аливаа хэлбэрээр өөрчлөн байгуулагдах тухай шийдвэр гаргасан;
- 2.1.28.үнэт цаас гаргагчийн Төлөөлөн удирдах зөвлөл нь өрийг хувьцаагаар солих тухай шийдвэр гаргасан;

2.1.29.үнэт цаас гаргагчийг татан буулгах, үйл ажиллагааг дуусгавар болгох тухай шийдвэр гаргасан;

2.1.30.үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд нөлөөлөл үзүүлэх эрх бүхий байгууллагын шийдвэр.

Гурав. Үнэт цаасны дотоод мэдээлэл эзэмшигч

3.1.Дотоод мэдээлэл эзэмшигчид дараах этгээд хамаарна:

3.1.1.Үнэт цаас гаргагч, түүний толгой болон охин, хараат компанийн эрх бүхий албан тушаалтан;

3.1.2.Үнэт цаас гаргагчийн нийтэд санал болгон гаргасан хувьцааны хяналтын багцыг эзэмшигч;

3.1.3.Өөрийн албан үүргээ хэрэгжүүлэхтэй холбогдон аль нэг үнэт цаас гаргагчтай холбоотой дотоод мэдээллийг олж авах боломжтой, эсхүл олж авсан Хороо, хөрөнгийн бирж, үнэт цаасны зах зээлд оролцогч зохицуулалттай этгээдийн ажилтан, тэдгээрийн холбогдох этгээд;

3.1.4.Үнэт цаас гаргагчийн хараат бус зөвлөхүүд болох хуульч, аудитор, үнэлгээчин, бусад санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагын эрх бүхий албан тушаалтан, ажилтан;

3.1.5.Энэ журмын 2.1.13-д заасны дагуу үнэт цаас гаргагчтай аливаа гэрээ байгуулсан, эсхүл гэрээ байгуулахаар завдаж буй этгээд, тэдгээр нь хуулийн этгээд бол эрх бүхий албан тушаалтан;

3.1.6.Энэ журмын 3.1.1-3.1.5-д заасан үүрэгт албан тушаал өөрчлөгдсөнөөс хойш 1 жилийн хугацаа өнгөрөөгүй байгаа этгээд.

3.2. Дотоод мэдээлэл эзэмшигч нь дараах үүрэгтэй:

3.2.1.үнэт цаасны зах зээлийн тухай хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллах

3.2.2.хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах

3.2.3.үнэт цаасны зах зээлийн талаар нийтэд мэдээлэх, холбогдох мэдээ мэдээллийг зохих хууль тогтоомжийн дагуу хөрөнгө оруулагчдад хүргэх

3.2.4.үнэт цаасны зах зээл дээр өөрт оногдсон ажил үүргийг ил тод, шударга гүйцэтгэх

3.2.5.байгууллага, иргэдээс гаргасан санал, өргөдөл, гомдлыг шуурхай шийдвэрлэх

3.2.6.дотоод мэдээллийн нууцыг хадгалах.

Дөрөв. Дотоод мэдээлэл эзэмшигчдийн үйл ажиллагаа

4.1.Дараах үйл ажиллагааг явуулсан тохиолдолд Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.1 дэх хэсэгт заасан хориглосон үйл ажиллагааг явуулсан гэж үзнэ:

4.1.1.дотоод мэдээлэл эзэмшиж буй давуу талаа ашиглан ашиг олох зорилгоор өөрийн болон бусад холбогдох этгээдийн дансаар үнэт цаасыг худалдах, худалдан авах арилжаа хийх;

4.1.2.дотоод мэдээллийг гуравдагч этгээдэд дамжуулах, мэдээлэх, эсхүл гуравдагч этгээд дотоод мэдээллийг олж авах нөхцөлийг бүрдүүлэх;

4.1.3.дотоод мэдээлэл ашиглан үнэт цаас худалдаж авах, худалдахыг гуравдагч этгээдэд зөвлөх, санал болгох;

4.1.4. дотоод мэдээллийг эзэмшиж буй гуравдагч этгээд, өөрийн болон бусад холбогдох этгээдийн дансаар үнэт цаасыг худалдах, худалдан авах, бусдад санал болгох, дотоод мэдээллийг дамжуулах, түүнчлэн дотоод мэдээллийг олж авах нөхцөлийг бүрдүүлэх;

4.1.5. энэ журмын 3.1.5-д заасан этгээд нь дотоод мэдээлэл эзэмшиж байх хугацаандаа гэрээ хэлцэл хийж буй үнэт цаас гаргагчийн болон түүний холбогдох этгээдийн үнэт цаасыг худалдах, худалдан авах, мөн түүнчлэн худалдан авах, худалдахыг гуравдагч этгээдэд зөвлөх, ятгах, үнэт цаас гаргагчтай хийж буй гэрээ хэлцлийн талаарх нийтийн хүртээл болоогүй байгаа мэдээллийг гуравдагч этгээдэд дамжуулах;

4.1.6. хөрөнгө оруулагчдыг төөрөгдөлд оруулах мэдээллийг нийтийн хүртээл болгох;

4.1.7. дотоод мэдээлэл эзэмшигчид нь энэ журмын 2.1-т заасан мэдээллийг нийтийн хүртээл болгохоос өмнө уг мэдээллийг санамсаргүй болон санаатайгаар бусдад дамжуулж, бусдад олж авах нөхцөлийг бүрдүүлэх.

4.2. Хороо, Хөрөнгийн бирж болон хуулийн дагуу эрх бүхий бусад төрийн хянах, зохицуулах байгууллагын шаардлагын дагуу мэдээлэл хүргүүлсэн нь энэ журмын 4.1 дэх заалтыг зөрчсөнд тооцогдохгүй.

4.3. Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхэлж буй этгээд нь хууль журмаар тогтоосон өөрийн чиг үүргээ хэрэгжүүлж байгаа дараах тохиолдлыг дотоод мэдээлэл ашиглан арилжаанд оролцсонд тооцохгүй:

4.3.1. Хууль тогтоомжийн дагуу баталгаажуулсан харилцагчийн захиалгыг биелүүлэх үйл ажиллагаа;

4.3.2. Аль нэг компанийн хяналтыг авах, нэгтгэхтэй холбоотой дотоод мэдээлэлд үндэслэсэн дараах үйл ажиллагаа:

4.3.2.1. хяналтыг нь авах гэж буй компанийн үнэт цаас эзэмшигчдээс тухайн саналыг хүлээн авах /хүлээн авахгүй байх/ талаар үүрэг хүлээх, дэмжих эсэх талаарх саналыг судлах;

4.3.2.2. хяналтыг авах, нэгтгэхтэй холбогдуулан худалдан авахаар санал болгож буй үнэт цаасны оронд санал болгож буй, эсхүл худалдан авах ажиллагааг санхүүжүүлэх зорилгоор гаргаж буй өөр үнэт цаасыг гаргах, байршуулах үйл ажиллагаанд андеррайтерын үйлчилгээ үзүүлэх;

4.3.2.3. хяналтыг авах, нэгтгэхтэй холбогдуулан худалдан авахаар санал болгож буй үнэт цаасны төлбөрийг төлөхтэй холбоотой ажиллагаа;

4.3.3. Хууль тогтоомжийн хүрээнд гүйцэтгэсэн гүйлгээтэй холбогдон гарах эрсдэлийг бууруулах зорилгоор авч хэрэгжүүлсэн арга хэмжээ;

4.3.4. Хороо болон хөрөнгийн биржийн дүрэм журмын дагуу нийтийн хүртээл болгох мэдээлэлд хамаарахгүй мэдээлэлд үндэслэн хийсэн ажил, гүйлгээ;

Тав. Үнэт цаасны зах зээлийг урвуулан ашиглах

5.1. Үнэт цаасны тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.1 дэх хэсэгт заасан үнэт цаасны зах зээлийг урвуулан ашиглах “бусад арга хэлбэр” гэдэгт дараах үйлдлийг ойлгоно:

5.1.1. олон нийтийн мэдээллийн хэрэгсэл болон интернет ашиглан олон нийтийг төөрөгдөлд оруулсан, бодит бус, хуурамч мэдээлэл цацах, амлалт өгөх замаар үнэт цаасны үнэ ханш болон эрэлт, нийлүүлэлтэд нөлөөлөхөөр хуурамч мэдээлэл тараах;

5.1.2. үнэт цаасны арилжааны хаалтын ханшинд зохиомлоор нөлөөлөх зорилгоор 2 ба түүнээс дээш удаа цөөн тоо ширхгээр үнэт цаасыг худалдах, худалдан авах хэлцэл хийх;

5.1.3. тодорхой үнэт цаасны өмчлөгч нь өөрчлөгдөхгүй хуурамч гүйлгээ хийх эсхүл нэгдмэл сонирхолтой этгээдүүдийн хооронд үнэт цаасыг 2 ба түүнээс дээш удаа худалдах,

худалдан авах хэлцэл хийх;

5.1.4. тодорхой үнэт цаасны арилжаа идэвхтэй явагдаж байгаа мэт олон давтамжтай хэлцлүүдийг зах зээлийн оролцогчдыг төөрөгдүүлэх зорилгоор үгсэн тохиролцож хийх;

5.1.5. үнэт цаасны үнэ ханшид зохиомлоор нөлөөлөх зорилгоор урьдчилан тохирсон талууд нэг төрлийн үнэт цаасыг ижил үнээр, ижил хэмжээгээр 2 ба түүнээс дээш удаа худалдах, худалдан авах захиалгыг зэрэг өгч хэлцэл хийх;

5.1.6. нөлөө бүхий хувьцаа эзэмшигч нь үнэт цаасны үнэ ханшийг зохиомлоор өсгөх, (бууруулах) зорилгоор үнэт цаасыг худалдан авах, (худалдах) үнийг өсгөж, бууруулах, цөөн тооны үнэт цаасыг 2 ба түүнээс дээш удаа худалдах, худалдан авах хэлцэл хийж, үнэт цаасны ханш тодорхой түвшинд хүрсний дараа худалдах, худалдан авах замаар ашиг олох;

5.1.7. 2 буюу түүнээс дээш удаад үнэт цаасны ханшийг зохиомлоор өсгөх, бууруулах зорилгоор идэвхтэй арилжааг урьдчилан зохион байгуулах;

5.1.8. үнэт цаасны зохиомол эрэлт, нийлүүлэлтийг үүсгэж зохиомлоор ханшийн өсөлт, бууралтыг бий болгох;

5.1.9. зохицуулалттай этгээд, түүний эрх бүхий албан тушаалтан нь өөрсдийн мэдэлд байгаа болон холбогдох этгээдийн дансуудыг ашиглан өөрт байгаа мэдээллээ давуу байдалтайгаар ашиглан захиалга хийх;

5.1.10. зохицуулалттай этгээд, түүний эрх бүхий албан тушаалтан нь харилцагчийн захиалгаас түрүүлж өөрийн эзэмшлийн данснаас захиалга оруулах, харилцагчийн өгсөн захиалга нь тухайн үнэт цаасны үнэ ханшид нөлөөлөхүйц байгаа тохиолдолд өөрийн болон компанийн дансаар тухайн үнэт цаасыг худалдах, худалдан авах, эсхүл гуравдагч этгээдийг худалдах болон худалдан авахыг ятгах;

5.1.11. цахим арилжааны системд биелүүлэх зорилгогүй тодорхой үнэт цаасыг худалдахаар санал болгож буй үнээс бага, худалдан авахаар санал болгож буй үнээс өндөр үнээр захиалга өгч, хэлцэл хийгдэхээс өмнө саналаа 2 ба түүнээс дээш удаа татах замаар үнэ ханшид зохиомлоор нөлөөлөх оролдлого хийх;

5.1.12. харилцагчийн өгсөн үнэт цаас худалдах болон худалдан авах захиалгын төрөл, хүчинтэй байх хугацаа, тоо ширхэг, нэгж үнийг харилцагчийн зөвшөөрөлгүйгээр өөрчлөх;

5.1.13. дотоод мэдээлэл эзэмшигч, түүний холбогдох этгээд үнэт цаас, түүнд суурилсан санхүүгийн хэрэгслийн арилжаанд дотоод мэдээлэл ашиглан оролцох.

5.2. Үнэт цаасны тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.1 дэх хэсэгт заасан үнэт цаасны зах зээлийг урвуулан ашиглах “бусад арга хэлбэр” гэдэгт энэ журмын 5.1.1-5.1.13-т заасан үйлдлүүдээс гадна дараах зорилго бүхий үйлдлүүдийг хамааруулж болно:

5.2.1. үнийг зохиомлоор бууруулан хямд үнээр худалдаж авах эсхүл үнийг зохиомлоор өсгөн өндөр үнээр худалдах үйлдэл, ийм үйлдэл хийхийг тушаасан, даалгасан дээд шатны эрх бүхий этгээдийн бичгээр болон амаар өгсөн шийдвэр;

5.2.2. үнэт цаасны үнийг зохиомлоор өсгөн өндөр үнээр худалдах;

5.2.3. анхдагч зах зээлд гаргаж буй үнэт цаасны үнэд нөлөөлөх;

5.2.4. компанийн хэлбэрийг өөрчлөх үед үнэт цаасны үнэ ханшид нөлөөлөх;

5.2.5. компани хувьцаагаа хуваах, нэгтгэх үед үнэт цаасны үнэ ханш болон хувьцаа хөрвүүлэхэд нөлөө үзүүлэх;

5.2.6. гуравдагч этгээдийн активыг худалдан авах /худалдах сонирхол төрүүлэх болон худалдах/ худалдан авахаас татгалзах нөхцөлийг бүрдүүлэх;

5.2.7. хувьцаат компанийн хувьцааг заавал болон сайн дурын үндсэн дээр худалдан авахтай холбоотойгоор үнэт цаасны үнэ ханшид нөлөөлөх;

5.2.8. худалдаж авахаар санал болгох үнэ бусад томоохон хэлцэлд зохиомлоор нөлөөлөх;

5.2.9. зах зээлийн индексэд ач холбогдол бүхий үнэт цаасны үнэ ханшид зохиомлоор нөлөөлөх;

5.2.10. мэргэжлийн хөрөнгө оруулагчдын санхүүгийн тайланд нөлөөлөх;

5.2.11. мэргэжлийн хөрөнгө оруулагчдын эзэмшиж байгаа үнэт цаасны үнэ ханшид зохиомлоор нөлөөлөх;

5.2.12. мэргэжилтэн болон шинжээчдийн дүгнэлт, зөвлөмжид өөрчлөлт үзүүлэх

зорилгоор үнэт цаасны үнэ ханшид зохиомлоор нөлөөлөх;

5.2.13. тухайн үнэт цаасны арилжааг идэвхтэй харагдуулах зорилгоор арилжааны тоо хэмжээнд зохиомлоор нөлөөлөх;

5.2.14. үнэт цаас гаргагч буюу нөлөө бүхий хувьцаа эзэмшигчийн зүгээс их хэмжээний хэлцэл болон багцын арилжаа явуулахтай холбоотойгоор үнэ ханшид зохиомлоор нөлөөлөх;

Зургаа. Үнэт цаасны зах зээлийг урвуулан ашиглахаас урьдчилан сэргийлэх

6.1. Зохицуулалттай этгээд үнэт цаасны зах зээлийг урвуулан ашиглахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр дараах нийтлэг үүрэг хүлээнэ:

6.1.1. үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.1-д заасан үнэт цаасны зах зээлд хуурамч арилжаа хийх, үнэт цаасны үнэ ханшийг зохиомлоор тогтоох, үнэт цаасны зах зээлд оролцогч, харилцагчийг хууран мэхлэх замаар арилжаанд оролцуулах, эсхүл оролцуулахгүй байх зорилготой үйлдлүүд, энэ журмын 5 дугаар зүйлийн 5.1.1-5.1.13, 5.2.1-5.2.13 дахь заалтуудад заагдсан үйлдлүүдийг хийхгүй байх;

6.1.2. энэ журмын 6.1.1-д заасан үйлдлүүдийг хийхээс сэргийлсэн дотоод хяналтын тогтолцоо, дараалсан болон давхар хяналтын тогтолцоо бүрдүүлэн ажиллах;

6.1.3. бүртгэлийн болон мэдээлэл, тайлагналын зохистой бүтэц, стандартад шилжих;

6.1.4. үнэт цаасны зах зээлийн хууль тогтоомж зөрчсөн, зах зээлийг урвуулан ашиглах зорилго агуулсан харилцагчийн болон холбогдох этгээдийн үнэт цаасны захиалгыг хүлээн авахгүй, татгалзах;

6.1.5. харилцагчийн олон нийтэд мэдээлэгдээгүй, үнэт цаасны үнэ ханшид нөлөөлж болохуйц арилжааны мэдээ, санхүүгийн болон бусад нууц мэдээллийг ашиглах, дамжуулахгүй байх;

6.1.6. сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхгүй байх, хэрвээ хийсэн бол энэ талаарх мэдээллийг өөрийн компанийн удирдлагад ил тод мэдэгдэх;

6.1.7. дотоод хяналтын ажилтан нь компанийн үнэт цаасны арилжааны үйл ажиллагаа болон харилцагчийн захиалга хүлээн авах, биелүүлэх үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж ажиллах;

6.1.8. компанийн болон өөрийн дансаар дамжуулан зах зээлийг урвуулан ашиглах үйлдэл гаргахгүй байх;

6.1.9. харилцагчийн захиалгын гэрээ, дилерийн даалгавар, мөнгө хүссэн өргөдөл зэрэг үнэт цаасны арилжааны аливаа анхан шатны баримтууд, утсаар хүлээн авсан захиалга, харилцагчийн факс, и-мэйлээр ирүүлсэн захиалгыг бүртгэж, хадгалах;

6.2. Үнэт цаасны зах зээлийг урвуулан ашиглахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр брокер дараах үүргийг хэрэгжүүлнэ:

6.2.1. брокер нь мэргэжлийн үнэмлэх бүхий этгээд мөн эсэхийг шалгах;

6.2.2. брокер нь хууль бус үйл ажиллагаа явуулж байсан эсэх, гэмт хэрэгт холбогдож байсан эсэхийг шалгах;

6.2.3. брокероор ажилласан түүхийг шалгана. Тухайн брокерийн урьд нь ажиллаж байсан Брокер, дилерийн компани, харилцаж байсан харилцагч нарын талаарх мэдээлэл болон тэдгээр харилцагч нарын мэдээллийг дараагийн арилжаанд ашигласан эсэхийг шалгах;

6.2.4. брокер нь харилцагчид үйлчлэх зохих шаардлагыг хангаж байгаа эсэхийг шалгана. Шаардлагатай түвшний ажлын байр, техник, тоног төхөөрөмж, технологи, программ хангамж, боловсон хүчин байгаа эсэхийг шалгах;

6.3. Үнэт цаасны зах зээлийг урвуулан ашиглахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр дилер дараах үүргийг хэрэгжүүлнэ:

6.3.1. дилер нь арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй компанийн хувьцааны үнэ, ханшид нөлөөлж байгаа эсэхийг шалгах;

6.3.2. дилер нь брокероос авсан захиалгыг үнэн зөв тэмдэглэсэн эсэхийг шалгаж, захиалгын хуудсанд бичигдсэн захиалга болон явагдсан арилжааг тулгах;

- 6.3.3. их хэмжээний хэлцэл тус бүрийг шалгах;
- 6.3.4. ханшийн өсөлт, бууралт ихтэй /15 хувиас их/ арилжааг шалгах;
- 6.3.5. дилерийн дансанд арилжигдсан үнэт цаасны үнэ, ханшийн зөрүү, харилцагчийн дансны үнэ, ханшийн зөрүүг шалгах;
- 6.3.6. дилерийн хийсэн арилжааны долоо хоног, сар, улирлын давтамжийг шалгах;
- 6.3.7. Арилжаа эрхлэх байгууллагын зүгээс дилерийн үйл ажиллагаанд хяналт тавьж байгаа эсэхэд давхар хяналт тавих;
- 6.4. Үнэт цаасны зах зээлийг урвуулан ашиглахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр хөрөнгө оруулалтын зөвлөх нь дараах үүргийг хэрэгжүүлнэ:
 - 6.4.1.хөрөнгө оруулалтын зөвлөх нь үйлчлүүлэгчийн дотоод мэдээллийг ашиглаж байгаа байдалд хяналт тавих;
 - 6.5. Үнэт цаасны зах зээлийг урвуулан ашиглахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр итгэмжлэн удирдах үйл ажиллагааг хэрэгжүүлэгч дараах уургийг хэрэгжүүлнэ:
 - 6.5.1.итгэмжлэн удирдах үйл ажиллагааг хэрэгжүүлэгч итгэмжлүүлэгчийн хувьцааг хувьдаа худалдан авсан эсэхийг шалгах;
 - 6.5.2.итгэмжлэл хүчин төгөлдөр эсэх, итгэмжлэлээр олгосон үйлдэл тодорхой эсэх, зааварчилгаатай эсэхийг шалгах;
 - 6.5.3.гэрээний нөхцөл, журмыг шалгах;
 - 6.6. Үнэт цаасны зах зээлийг урвуулан ашиглахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр андеррайтер дараах үүргийг хэрэгжүүлнэ:
 - 6.6.1.андеррайтер нь үйл ажиллагаа тогтмол явуулж байгаа эсэхийг шалгах;
 - 6.6.2.андеррайтерийн үйл ажиллагааны талаар олон улсын холбогдох байгууллагуудаас мэдээлэл авч шалгах;
 - 6.6.3.Монгол Банктай хамтарсан шалгалт хийх, Санхүүгийн мэдээллийн албанаас мэдээлэл авч шалгах;
 - 6.6.4.үнэт цаас гаргаж, хөрөнгө босгож байгаа үйл ажиллагаа зориулалтын дагуу хийгдсэн эсэхэд хяналт тавих, хоёр долоо хоног, нэг сар, улирлаар тайлан авч шалгах;
 - 6.7. Үнэт цаасны зах зээлийг урвуулан ашиглахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр өмчлөх эрхийн бүртгэлийн үйл ажиллагаанд дараах үүргийг хэрэгжүүлнэ:
 - 6.7.1.өмчлөх эрхийн бүртгэлийн байгууллага дахь бүртгэл үнэн, зөв хийгдэж байгаа эсэхэд хяналт тавих, хувьцаат компани бүрээр, өмчлөгч бүрээр хийгдэх бүртгэлийг шалгах;
 - 6.7.2.бүртгэлийн үйл ажиллагааг бүхэлд нь хянах;
 - 6.8. Үнэт цаасны зах зээлийг урвуулан ашиглахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр үнэт цаасны клирингийн үйл ажиллагаанд дараах үүргийг хэрэгжүүлнэ:
 - 6.8.1.эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааг мэргэшсэн, тогтвортой байдлаар явуулж байгаа эсэхийг шалгах;
 - 6.8.2.ашиглаж байгаа программ хангамж шаардлага хангаж байгаа эсэхийг шалгах;
 - 6.8.3.IOSCO-ийн зарчмуудыг мөрдөж байгаа эсэхийг шалгах;
 - 6.8.4.тооцооны үйл ажиллагаанд тавих хяналтын горимыг шалгах;
 - 6.8.5.үнэт цаасны арилжааны явцад хийгдсэн гэрээ, хэлцэл цуцлагдах аливаа эрсдэлийг бууруулах зорилготой тусгай сангийн үйл ажиллагааг шалгах;
 - 6.9. Үнэт цаасны зах зээлийг урвуулан ашиглахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр үнэт цаасны төлбөр тооцооны үйл ажиллагаанд дараах үүргийг хэрэгжүүлнэ:
 - 6.9.1.арилжааны төлбөрийн үйл ажиллагааны явцад олж авсан мэдээллийг ашиглаж байгаа байдалд хяналт тавих;
 - 6.9.2.үнэт цаасны зах зээлд давамгай байдал үүсгэх үйл ажиллагаа явуулж байгаа эсэхэд хяналт тавих;
 - 6.9.3.харилцагч хууль бусаар татах үйл ажиллагаа явуулж байгаа эсэхэд хяналт тавих;
 - 6.10. Үнэт цаасны зах зээлийг урвуулан ашиглахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаанд дараах үүргийг хэрэгжүүлнэ:
 - 6.10.1.төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагааны явц дахь дотоод мэдээллийн нууцлалд хяналт тавих, дотоод мэдээлэл эзэмшигчдэд хяналт тавих;
 - 6.10.2.мэдээллийн аюулгүй байдалд хяналт тавих;

6.10.3. төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагааны явц дахь өмчлөх эрхийн шилжилт, хөдөлгөөнд хяналт тавих;

6.10.4. төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагааны автоматжуулалт, мэдээллийн аюулгүй байдлын олон улсын стандарт мөрдөж байгаа байдал, боловсон хүчний бодлого, үйл ажиллагаанд хяналт тавих;

6.10.5. мэдээллийн нөөц хувилбарын хадгалалт, архивлалт, нууцлалтад хяналт тавих;

6.11. Үнэт цаасны зах зээлийг урвуулан ашиглахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр кастодианы үйл ажиллагаанд дараах үүргийг хэрэгжүүлнэ:

6.11.1. өмчлөх эрхийн бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавих.

Долоо. Арилжаа эрхлэх байгууллагын хүлээх үүрэг

7.1. Үнэт цаасны арилжааг ил тод, алдаагүй, шударгаар зохион байгуулж, хяналт тавих;

7.2. Үнэт цаасны арилжааны явц болон арилжаа явагдаж дууссаны дараа үнэт цаасны үнэ ханшийн хэлбэлзэл, арилжигдсан тоо ширхэг зэргийг үндэслэн зөрчилтэй байж болзошгүй сэжиг бүхий хэлцлүүдийг бүртгэн нарийвчилсан шалгалт явуулах;

7.3. Арилжааны хэмжээ болон ханшийн өөрчлөлтийн дагуу зах зээлийг урвуулан ашиглах зорилготой хэлцэл, эсхүл үйлдэл хийгдсэн эсэхийг шалгаж, зөрчил илэрсэн тохиолдолд шалгалтын тайланг холбогдох нотлох баримтын хамт Хороонд хүргүүлэх;

7.4. Энэ журмын 9.2.7.4-т заасан Хорооны Улсын байцаагчийн дүгнэлт гарахаас өмнө шалгалтын талаар олон нийтэд мэдээлэхгүй байх.

Найм. Үнэт цаас гаргагч болон харилцагч, хөрөнгө оруулагч тэдгээрийн холбогдох этгээдийн хүлээх үүрэг

8.1. Энэ журмын 5-д заасан үнэт цаасны зах зээлийг урвуулан ашиглах үйлдэл гаргахгүй байх;

8.2. Зах зээлийг урвуулан ашиглах үйлдэлд тооцогдох, эсхүл үнэт цаасны үнэ ханшид зохиомлоор нөлөөлөх зорилго агуулсан худалдах, худалдан авах захиалга өгөхгүй байх;

8.3. Хорооны Улсын байцаагчийг шалгалт хийх нөхцөл бололцоогоор бүрэн хангаж, шаардлагатай мэдээ, мэдээлэл, гэрээ хэлцлийг хугацаанд нь бүрэн гаргаж өгөх;

8.4. Тодорхой үнэт цаасыг худалдан авахад дансан дахь бэлэн мөнгө хүрэлцэхгүй тохиолдолд үнэт цаас худалдан авах захиалга өгөхгүй байх;

8.5. Хорооны 2015 оны 443 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын журам”-ын дагуу олон нийтэд мэдээлж ажиллах;

8.6. Үнэт цаас гаргагч нь халаасны хувьцаа худалдан авах мэдээллийг олон нийтэд мэдээлэх.

Ес. Хяналт

9.1. Дотоод мэдээллийг нийтэд мэдээлэхтэй холбоотой хяналт:

9.1.1. Үнэт цаас гаргагч, зохицуулалттай этгээд болон мэдээллийг нийтийн хүртээл болгох үүрэг бүхий бусад байгууллага нь энэ журмын 2.1-т заасан мэдээллүүдийг үнэн зөв, бүрэн төгс, цаг тухайд нь нийтэд хүргэх үүрэгтэй.

9.1.2. Энэ журмын 4.1 дэх заалтыг зөрчсөн гэж үзэж, холбогдох арга хэмжээ авахын тулд тухайн хуулийн этгээдийн холбогдох ажилтан нь дотоод мэдээлэл эзэмшигч мөн эсэх, дотоод мэдээллийг мэдсэн байх боломжтой эсэх зэрэг нөхцөл байдлыг сайтар судлан тогтоосон байна.

9.1.3. Дотоод мэдээллийг нийтэд мэдээлэх, хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих ажлын хүрээнд Хорооны улсын байцаагч дараах эрх эдэлж, үүрэг хүлээнэ:

9.1.3.1. Дотоод мэдээллийг тогтоосон хугацаанд нийтийн хүртээл болгохыг үнэт цаас гаргагч, зохицуулалттай этгээдээс шаардах;

9.1.3.2. Нийтийн хүртээл болгох шаардлагатай дотоод мэдээллийг нийтийн хүртээл болгох тохиромжтой хугацааг тогтоох;

9.1.3.3. Үнэт цаас гаргагч, үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээдийн дотоод мэдээлэл, түүнийг эзэмшигчдийн талаарх мэдээллийг гаргуулан авах, танилцах;

9.1.3.4. Энэ журмын 4.1-т заасан үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх зорилгоор үнэт цаас гаргагч болон зохицуулалттай этгээдэд зайны болон газар дээрх хяналт шалгалтыг хийх;

9.1.3.5. Хяналт шалгалтын ажлын хүрээнд өөрийн болон бусдын нэрийн өмнөөс дотоод мэдээлэл ашиглан үнэт цаасны арилжаанд оролцсон байж болзошгүй гэж үзсэн этгээдийн үнэт цаасны арилжааны бүхий л мэдээллийг арилжаа эрхлэх байгууллага, үнэт цаасны клирингийн, төлбөр тооцооны байгууллага, үнэт цаасны хадгаламжийн байгууллага, үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээдээс гаргуулан авах;

9.1.3.6. Дотоод мэдээлэл эзэмшигч этгээдийн гаргасан зөрчлийг гэмт хэргийн шинж чанартай гэж үзвэл холбогдох нотлох баримтыг бүрдүүлэн хууль хяналтын байгууллагад шилжүүлэх;

9.1.3.7. Хяналт шалгалтын ажлын хүрээнд олж авсан дотоод мэдээллийн нууцыг хадгалах, хувийн ашиг сонирхолд ашиглахгүй, гуравдагч этгээдэд санаатай болон санамсаргүй дамжуулахгүй байх.

9.2. Үнэт цаасны зах зээлийг урвуулан ашиглахтай холбоотой хяналт

9.2.1. Зохицуулалттай этгээд үнэт цаасны зах зээлийг урвуулан ашиглахаас урьдчилан сэргийлэх, дотоод хяналт шалгалтыг хэрэгжүүлнэ. 9.2.2. Арилжаа эрхлэх байгууллага нь үнэт цаасыг зохих журмын дагуу бүртгэн, техник программ хангамжийн найдвартай байдлыг хангаж, олон нийтийг үнэт цаасны арилжааны мэдээ, мэдээллээр хангаж, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалахад чиглэгдсэн хяналт шалгалтыг хэрэгжүүлнэ.

9.2.3. Хорооноос авч явуулах үнэт цаасны зах зээлийг урвуулан ашиглахаас урьдчилан сэргийлэх, хяналт шалгалт хийх, зөрчлийг таслан зогсоох үйл ажиллагааг Хорооны Хяналт шалгалт, зохицуулалтын газар, улсын байцаагч хэрэгжүүлнэ.

9.2.4. Хяналт шалгалтын ажлыг дараах хэлбэрээр явуулна:

9.2.4.1. зайны хяналт;

9.2.4.2. газар дээрх хяналт;

9.2.5. Үнэт цаасны арилжааны өдөр тутмын үйл ажиллагаанд “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн арилжааны хяналтын “Investigation manager”, “Market Replay”, “Surveillance” программуудыг ашиглан зайны хяналт тавина.

9.2.6. Зайны хяналтын үед:

9.2.6.1. хяналтын программаар “Монголын хөрөнгийн бирж” ХК-д бүртгэлтэй хувьцаат компаниудын жагсаалт ба өдөр бүрийн үнэт цаасны арилжааны хэлцлийн задаргааг харж, хяналтын программ дээр үүссэн сэрэмжлүүлэх дохионы дагуу /Alert/ сэжигтэй хэлцлүүдийг дэлгэрүүлэн шалгаж зөрчилтэй гэж үзсэн хэлцлүүдийн баримтыг “Монголын хөрөнгийн бирж” ХК, ҮЦК-иас гаргуулан авч нарийвчлан шалгана.

9.2.6.2. үнэт цаасны хэлцлүүдийг графикаар харуулах, тухайн хэлцлийн худалдан авах, худалдах захиалгыг оруулсан огноо, цаг минутыг хараад үнэт цаасны арилжааны явцад хувьцааны ханш хэт өссөн, буурсан хэлцэл болон цөөн тоо ширхгээр хийгдсэн хэлцлийг шалгана.

9.2.6.3. үнэт цаасны үнэ ханшийн хэлбэлзэл, арилжигдсан тоо ширхэг зэргийг

үндэслэн зөрчилтэй байж болзошгүй сэжигтэй хэлцлийг худалдан авсан, худалдсан дансны эзэмшигчид нь нэгдмэл сонирхолтой эсэхийг шалгана.

9.2.6.4. тухайн сэжиг бүхий арилжааны хэлцлүүд, арилжаанд оролцсон талуудын мэдээлэл зэргийг хяналтын программаас татан авч, хэлцлийн авах, зарах захиалгын дараалал, арилжааны программд журмын дагуу үнэн, зөв шивж оруулсан эсэх, үнэт цаасны ханшид үзүүлсэн нөлөөлөл, цөөн тоо, ширхэгээр олон давтамжтай арилжаа хийгдсэн эсэхийг шалгана.

9.2.6.5. зайны хяналтаар сэжиг бүхий хэлцэл хийгдсэн гэж үзсэн тохиолдолд тухайн үнэт цаасны арилжааг шалгуулах тухай хүсэлтийг “Монголын хөрөнгийн бирж” ХК-д албан бичгээр гаргаж, шалгалтын тайлан, дүгнэлтийг мэргэжлийн байгууллагаар гаргуулан авна.

9.2.6.6. анхдагч зах зээлийн арилжаа болон бусад төрлийн үнэт цаасны /өрийн хэрэгсэл, үүсмэл үнэт цаас гэх мэт/ арилжаа явагдах тохиолдолд үнэт цаас нийлүүлэх үйл ажиллагаанд арилжаа зохион байгуулагч хэрхэн хяналт тавьж байгааг давхар хянан шалгана.

9.2.7. Газар дээрх хяналтын үед:

9.2.7.1. сэжиг бүхий хэлцэл хийхэд оролцсон талууд болох тухайн үнэт цаас гаргагч, түүний толгой, охин болон хараат компани, тэдгээрийн эрх бүхий албан тушаалтан түүний холбогдох этгээдүүд, үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээд, тэдгээрийн эрх бүхий албан тушаалтан түүний холбогдох этгээдүүд, хөрөнгө оруулагч, тэдгээрийн холбогдох этгээдүүдийн хийсэн сэжиг бүхий хэлцлүүдийн анхан шатны баримтыг нэг бүрчлэн гаргуулан авна.

9.2.7.2. дээрх сэжиг бүхий хэлцэл хийхэд оролцсон холбогдох этгээдүүдтэй биечлэн уулзаж, газар дээрх шалгалтын ажлыг зохион байгуулна. Шаардлагатай тохиолдолд албан ёсны тайлбар, тодруулгыг бичгээр гаргуулан авна.

9.2.7.3. арилжаа эрхлэх байгууллага болон үнэт цаасны клирингийн, төлбөр тооцооны байгууллагаас шалгалтад шаардлагатай баримт материал, бүртгэл, судалгаа, тайлбар тодруулга зэрэг бүхий л мэдээллийг бичгээр гаргуулан авна.

9.2.7.4. Хорооны Улсын байцаагч нь дээрх зайны болон газар дээрх хяналт, шалгалтын үйл ажиллагааг хэрэгжүүлсний үндсэн дээр, “Монголын хөрөнгийн бирж” ХК-иас ирүүлсэн шалгалтын тайлан, нотлох баримтыг хянаж үзээд арилжаанд оролцсон талууд нь Үнэт цаасны зах зээлийг урвуулан ашигласан үйлдэл гаргасан эсэхэд дүгнэлт гаргана.

Арав. Хариуцлага

10.1. Хорооны Хяналт шалгалт, зохицуулалтын газар энэхүү журмын биелэлтэд хяналт тавьж, уг журмыг зөрчсөн этгээдэд Хорооны Улсын байцаагч Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 89 дүгээр зүйлд заасан захиргааны хариуцлага хүлээлгэнэ.

10.2. Зохицуулалттай этгээд тэдгээрийн эрх бүхий албан тушаалтан нь үнэт цаасны зах зээлд дотоод мэдээлэл ашиглан арилжаанд оролцсон, зах зээлийг урвуулан ашиглах хууль бус зөрчлийг удаа дараа давтан үйлдсэн бол эрх бүхий албан тушаалтны үнэт цаасны зах зээлд мэргэжлийн ажил, үйлчилгээ явуулах эрхийг нь хүчингүй болгох арга хэмжээ авч, зохицуулалттай этгээдийн үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно.

10.3. Үнэт цаасны зах зээлд оролцогч, тэдгээрийн эрх бүхий албан тушаалтан, холбогдох этгээдийн үнэт цаасны зах зээлд дотоод мэдээлэл ашиглан арилжаанд оролцсон, зах зээлийг урвуулан ашигласан бол холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

10.4. Үнэт цаасны зах зээлд дотоод мэдээлэл ашиглан арилжаанд оролцсон, зах зээлийг урвуулан ашигласан үйлдэл нь гэмт хэргийн шинжтэй бол тус Хороо холбогдох баримт бичгийг эрх бүхий хууль хяналтын байгууллагад шилжүүлнэ.

-----oOo-----